



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2018



Сайншанд хот



Агуулга

Дэс дугаар	Агуулга, бүлгийн нэр	Хуудасны дугаар
1	1. Удирдлага, зохион байгуулалт	3
2	2. Аудитын үйл ажиллагааны талаар	5
3	2.1 Санхүүгийн тайлангийн аудит	5
4	2.1.1 Төсвийн шууд захирагчийн тайлан	5
5	2.1.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан	7
6	2.1.3 “2018 оны төсвийн хуулийн хэрэгжилтийн явц” сэдэвт санхүүгийн аудит	8
7	2.1.4 “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт санхүүгийн аудит	10
8	2.2 Гүйцэтгэлийн аудит	10
9	2.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудын хэрэгжилт, үр дүн /ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар/	11
10	2.2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөө/ ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар/	11
11	2.2.3 “Өмнөх онуудад орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүн” гүйцэтгэлийн аудит	12
12	2.2.4 “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит	13
13	2.2.5 “Орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн санд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудит	14
14	2.2.6 “Аймгийн орон нутгийн төсвийн татварын бус орлого бүрдүүлэх үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит	14
15	2.3 Нийцлийн аудит	15
16	2.3.1 “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт” нийцлийн аудит	15
17	2.3.2 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудит	16
18	2.3.3 “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн” нийцлийн аудит	17
19	3. Сургалт	18
20	3.1 Дотоод сургалт	18
21	3.2 Бусад байгууллагаас авах сургалт	18
22	4. Дотоод ажил, үйлчилгээ	20
23	4.1 Архив, бичиг хэрэг	21
24	4.2 Санхүү, нягтлан бодох бүртгэл	21
25	4.3 Ажилчдын ажиллах нөхцөл, шагнал урамшуулал	22
26	4.4 Олон нийттэй харилцах чиглэлээр хийсэн ажил	23



УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын дэвшүүлсэн “Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд 2018 онд нийт 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Ерөнхий аудитор тус байгууллагын бүтэц орон тоог 11 байхаар баталсан бөгөөд 2018 онд 11 орон тоотой, санхүү, гүйцэтгэл, нийцлийн алба гэсэн бүтцээр нийт 940 хүн/өдөр, 1161 илүү цаг ажиллалаа. Мөн 2018 оны 02 дугаар сараас нягтлан бодогч, дотоод ажил хариуцсан гэрээт ажилтныг авч ажиллуулж байна.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 6 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 санхүүгийн аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 215 байгууллага, тусгай санг аудитад хамруулахаас 50.2 хувь буюу 108 тайланд Төрийн аудитын газар, 49.8 хувь буюу 107 тайланд ХБАК-иуд дүгнэлт гаргаж, түүвэрт хамруулсан байна.



Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/191 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж Сайн аудит ХХК, Ингүүмэл жаргалант аудит ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллалаа.


Хараат бус аудитын компаниудын гүйцэтгэсэн ажлын чанарыг зохих журмын дагуу үнэлж дүгнэсэн бөгөөд “Ингүүмэл жаргалант аудит” ХХК 75 оноо авч “В”, “Сайн аудит” ХХК 80 оноо авч “В” үнэлгээ өгсөн.



Мөн санхүүгийн тайлангийн аудитаар 143 шууд захирагчийн тайланд дүгнэлт гаргаж, 48 шууд захирагчийн тайланг түүвэрт хамруулан, 2 шууд захирагчийн тайланд итгэл үзүүлж, 15 төвлөрүүлэн захирагчийн тайланд дүгнэлт гаргаж, төрийн болон орон нутгийн өмчит 6 санхүүгийн тайлан, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 тайланд тус тус дүгнэлт гаргалаа.

Аудитаар нийт 30,289.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж, аудитын явцад 1,544.3 сая төгрөгийн алдааг залруулж, 484.6 сая төгрөгийн 37 төлбөрийн акт тогтоон, 3,516.3 сая төгрөгийн 114 албан шаардлага бичиж, 342 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүллээ. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтээс нийт 1,166.6 сая төгрөгийн үр өгөөжийг тооцож, холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн.

/сая төгрөгөөр/



Тайлант онд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 39.0 сая төгрөгийн 23 төлбөрийн акт барагдаж биелэлт 49.8 хувьтай, 1,224.3 сая төгрөгийн 53 албан шаардлага хэрэгжиж биелэлт 34.8 хувьтай, 154 зөвлөмж хэрэгжиж биелэлт 45.0 хувийн хэрэгжилттэй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалтай санал дүгнэлт авсан 14 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 7 албан шаардлага хүргүүлснээс 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулаад байна.



АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР



2.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудитаар 143 шууд захирагчийн тайланд дүгнэлт гаргаж, 48 шууд захирагчийн тайланг түүвэрт хамруулан, 2 шууд захирагчийн тайланд итгэл үзүүлж, 15 төвлөрүүлэн захирагчийн тайланд дүгнэлт гаргаж, төрийн болон орон нутгийн өмчит 6 санхүүгийн тайлан, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 тайланд тус тус дүгнэлт гаргалаа. Мөн ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 санхүүгийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитаар 7,720.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 1,544.3 сая төгрөгийн алдааг залруулж, 40.7 сая төгрөгийн зөрчилд 26 төлбөрийн акт тогтоож, 685.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 32 албан шаардлага хүргүүлж, 5,449.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 258 зөвлөмж өгсөн байна. Мөн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан авсан 14 төсөв захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүллээ. Мөн аудитаар 117.0 сая төгрөгийн үр өгөөж тооцлоо.

2.1.1 Төсвийн шууд захирагчийн тайлан

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 143 төсвийн **Шууд захирагчийн** санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 48 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 2 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүллээ. Тус аудитаар 130 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 12 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгч ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй дараах зөрчлүүдийн улмаас “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Айраг сумын Цэцэрлэг: Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар 2017 онд цэцэрлэгийн багш ажилчдаас гадна үйлчилгээний 7 ажилтанд Засгийн газрын 2001 оны 90 дүгээр тогтоолын хавсралт 2.1 дэх заалтыг зөрчин нийт 2.9 сая төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосон.

Алтанширээ сумын Цэцэрлэг: МУ-ын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан хүүхдийн хоолны зардлын нормыг баримтлаагүйгээс цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 1.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн.



Иххэт сумын цэцэрлэг: Цэцэрлэгийн төсвийн хоол хүнсний зардлаас 2017 оны 12 сард 1.6 сая төгрөгийн цалингийн ашиг, НДШ-ийн зардлыг шилжүүлсэн,

Өргөн сумын Цэцэрлэг: Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас тэтгэвэрт гарсан ажилтанд 2 сарын цалинтай тэнцэх 938.2 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон.

Замын-Үүд сумын 1-р цэцэрлэг: МУ-ын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан хүүхдийн хоолны зардлын нормыг баримтлаагүйгээс цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн.

Замын-Үүд сумын 1-р сургууль: Тус сургууль Замын-үүд сумын Нийгмийн даатгалын тасагт 3.6 сая төгрөг, Татварын тасагт 6.6 сая төгрөг тус тус шилжүүлж авлага үүсгэсэн.

Сайншанд сумын 4 дүгээр сургууль: Сургуулийн дотуур байрны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор урсгал засварын зардлаас Худалдан авах ажиллагааны хууль зөрчин гэрээ хэлцэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв тооцоо, ажлын гүйцэтгэлгүйгээр Ти Эс Эя Ти Эй ХХК-д 8.8 сая төгрөг, Төгс хоёр эрдэнэ ХХК-д 3.3 сая төгрөг, Металл сервис ХХК-д 9.8 сая төгрөгийг шилжүүлж ажил гүйцэтгүүлсэн, мөн татварын хэлтэст 10.7 сая төгрөг төлж авлага үүсгэсэн.

Хатанбулаг сумын Соёлын төв: Татварын хэлтэст 2.3 сая төгрөг шилжүүлж авлага үүсгэсэн, иргэнд нүүрс худалдан авахаар мөнгө шилжүүлээд нүүрсээ аваагүй, төлбөр тооцоо нийлж баталгаажуулаагүй, хуулийн байгууллагад хандсан боловч хэрэгсэхгүй болгосон, номын санд гал гарсны улмаас гарсан хохирлын хэмжээг тогтоох комисс томилоогүй, тооллого, тооцоо хийгээгүй, номын санчийн өөрийнх нь тооцоогоор 358.4 сая төгрөгийн 1160 ширхэг ном ашиглах боломжгүй гэсэн жагсаалт гаргасан байна.

Даланжаргалан сумын Соёлын төв: Говь сүмбэр аймгийн Цахилгаан дамжуулах сүлжээний салбарт 9.7 сая төгрөг шилжүүлж авлага үүсгэсэн.

Зүүнбаян Соёлын төв: Аймгийн Чандмань-Илч ХХК-д 11.0 сая төгрөг, Татварын хэлтэст 4.3 сая төгрөг, Нийгмийн даатгалын хэлтэст 3.0 сая төгрөг, нэг иргэнд ажлын хөлс 4.0 сая төгрөг тус тус шилжүүлж авлага үүсгэсэн.


Замын-Үүд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: ИТХ-ын авто машины эвдрэлд холбогдох байгууллагын техникийн комиссын дүгнэлт гараагүй, өмч хамгаалах комисс тухайн хөрөнгийг нүд үзэж эвдрэл, гэмтлийн шинж байдлыг тодорхойлоогүй байхад нийт 12.2 сая төгрөгийн урсгал засвар хийгдсэн.



БНХАУ-ын Эрээн хотын ардын төлөөлөгч нарын албан ёсны айлчлалын арга хэмжээнд 120.0 мянган төгрөгийн үнэ бүхий 9 ширхэг мөнгөн аяга бэлэглэсэн гэх боловч эд хариуцагч тайлан гаргаагүй, тухайн мөнгөн аяга олгогдсон эсэхийг нотлох 1.1 сая төгрөгийн хүчин төгөлдөр анхан шатны зарлагын баримт байхгүй байсан.

Төсвийн шууд захирагчийн тайланд 2653.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн бөгөөд үүний 1314.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 29.9 сая төгрөгийн 25 төлбөрийн акт тогтоож, 464.3 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага хүргүүлээ. Мөн төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналттай холбоотой 195 зөвлөмжийг хүргүүлсэн. Хязгаарлалттай санал дүгнэлт авсан 12 төсвийн шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ. Тайлант онд 23.0 сая төгрөгийн акт барагдаж, 408.2 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжиж, 123 зөвлөмж хэрэгжээд байна.

2.1.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан



Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан цаглабарт хугацаанд 15 төсвийн **Төвлөрүүлэн захирагчийн** тайланд дүгнэлт гаргаж, 14 тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, Замын-Үүд сумын төвлөрүүлэн захирагчийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан: Гадаадын иргэн харьяатын газарт худалдан авч хүлээлгэн өгсөн 295.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 26.5 сая төгрөгөөр илүү бүртгэгдсэн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авах 18.0 сая төгрөгийн ажлын нэр, зориулалтыг өөрчилсөн, хөрөнгийн зардлыг буруу төлөвлөн зарцуулсан мөн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 8.9.3, 8.9.4-т заасан цаглабарт хугацаанд төрийн болон орон нутгийн өмчит 6 санхүүгийн тайланд аудит хийж “Чандмань бадрал” ОНӨХХК-д “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 тайланд тус тус “Зөрчилгүй” санал дүгнэлт өглөө.

Замын-Үүд сум дахь Чандмань бадрал ОНӨ ХХК: Тус компани 738.3 төгрөгийн цэвэр дүн бүхий үндсэн хөрөнгө, 141.1 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалын тооллого хийсэн гэж байгаа боловч бүртгэлийн үлдэгдэлтэй тулган шалгаж үр дүнг тооцож дүгнээгүй илүүдэл, дутагдал гарсан эсэх нь тодорхой биш байна.



2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 246.5 сая төгрөгийн авлага, 85.4 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Иргэн З.Очирбаттай шууд худалдах худалдан авах гэрээ байгуулан 41.5 сая төгрөгөөр экскаватор худалдан авсан.

“Бернаульский котлоостроительный завод”-той гэрээ байгуулж халаалтын зуух худалдан авсан гэх боловч иргэн М.Энхбатад 54.5 сая төгрөг шилжүүлсэн бөгөөд анхан шатны баримтгүй зэргийг үндэслэн хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

Аудитаар 1332.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 167.9 сая төгрөгийн алдааг залруулж, 10.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 44.6 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, нийт 13 зөвлөмжийг хүргүүллээ. Замын-Үүд сумын төвлөрүүлэн захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээд байна. Тайлант онд 10.8 сая төгрөгийн төлбөрийн акт бүрэн барагдаж, 19.6 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжиж, 12 зөвлөмж хэрэгжээд байна.

2.1.3 “2018 оны Төсвийн хуулийн хэрэгжилтийн явц” сэдэвт санхүүгийн аудит



ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар тус аудитыг 2018.09.01-2018.11.05 өдрийн хугацаанд гүйцэтгэж “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг өглөө.

Аудитаар сумдын хөрөнгө борлуулсны орлого, хөрөнгийн орлогыг үйл ажиллагааны болон шууд бус орлогоос салгаж төлөвлөөгүй байна. Үүний улмаас 171.4 сая төгрөгийн хөрөнгө борлуулсны орлого төлөвлөөгүй байна.

Сумын сургуулиудын төсвийн нийт санхүүжилтийн дүнд аймгийн Санхүү хэлтэс гэсэн нэр дээр Сайншанд суманд баригдаж, дараа онд ашиглалтад орох бага сургуулийн урсгал зардалд 1,607.5 сая төгрөгийг илүү батлуулсан байна. Мөн сумдын Эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийн төсөвт “төрийн сангийн нөөц” нэрээр 18.5 сая төгрөгийг илүү хуваарилан батлуулсан.

Суурь зарлагад тооцох хөрөнгийн зардлыг буруу төлөвлөн зарцуулж байна. Суурь зарлагад тооцсон хөрөнгийн зардал /орон нутгийн хөрөнгө оруулалт/ нь Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.1-д заасан “орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардал”-д тавигдах шаардлагыг хангахгүй байна. Орон нутгийн төсвийн суурь зарлагад тооцсон хөрөнгийн зардал/орон нутгийн хөрөнгө оруулалт/-ын 3,788.1 сая төгрөг буюу 68 хувь нь аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй байгаа бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарч байна.



Сангийн сайдын баталсан улсын төсөвт төвлөрүүлэх орлогын сар, улирлын хуваарийн дагуу 2018 оны 1-3 дугаар улиралд нийт 1,876.1 сая төгрөгийг төвлөрүүлэх ёстой байсан боловч орлогын төлөвлөгөөг огт биелүүлээгүй.

Доод шатны төсвөөс буюу Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт орлого төвлөрүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.2 дахь заалтыг баримтлаагүй байна. Үүний улмаас Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт 1,224.6 сая төгрөгийн орлогыг илүү татан төвлөрүүлэхээр тооцсон байна.

Аймаг, сумын ИТХ-аар төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг харилцан адилгүй баталж байна. Зарим сумдад ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнг батлаагүй тохиолдол ч гарч байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, хүрэх үр дүн, чанарын болон тоон үзүүлэлтэд баримтлах шалгуур үзүүлэлт, заавар журам байхгүй байгаагаас шалтгаалан эдгээр үзүүлэлтийг баталж мөрдөх үйл явц хангалтгүй байна. Сумдын ерөнхий боловсролын сургуулиудын төсвийн хуваарийг дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр 1,591.5 сая төгрөгөөр өөрчилж, 998.2 сая төгрөгийн урсгал зардлыг хөрөнгө оруулалтын зориулалтаар тендер зарлан гүйцэтгүүлсэн байна.

Урьд оны үлдэгдлээс зарцуулахаар батлагдсан 500 сая төгрөгийн төсвийг хэтрүүлэн 651.6 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 151.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Барилга байгууламжийн ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэсэн 2 ТАХ, баталгаажсан зураг төсөлгүй 3 ТАХ, зураг төсөлд өөрчлөлт оруулж ажил гүйцэтгэхдээ зохиогчоор баталгаажуулаагүй 1 ТАХ байна.

Улсын төсвөөс санхүүжигдэн гүйцэтгэж буй барилга байгууламжийн гэрээний үүргийн хэрэгжилтэд захиалагч, зохиогчийн тавих хяналт сул байгаагаас зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл чанаргүй байх, норм стандартын дагуу гүйцэтгэхгүй байх эрсдэл бий болж байна.

Аудитаар нийт 17,939.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 406.4 сая төгрөгийн төлбөрийн нэг акт, хөрөнгийг данс бүртгэлд тусгах тухай 338.5 сая төгрөгийн нэг албан шаардлага өгч, 17,194.7 сая төгрөгийн зөрчилд нийт 12 зөвлөмж өгснөөс тайлант онд 2 зөвлөмж хэрэгжиж 700.0 сая төгрөгийн үр өгөөж тооцоод байна. Мөн данс бүртгэлд тусгах 101.6 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжээд байна.



2.1.4 “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт санхүүгийн аудит



ҮАГ-ын нэгдсэн удирдамж аймгийн Төрийн аудитын газрын төлөвлөгөөг үндэслэн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт санхүүгийн аудитыг 2018.08.27-2018.11.05-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитаар “Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн актын зарим заалтууд уялдахгүй байна” гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгч ажиллалаа.

Аудитаар илэрсэн зөрчлөөс дурдвал: Төрийн сангийн үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг зөрчиж 157.1 сая төгрөгийн орлого бууруулах гүйлгээ хийсэн, 559.3 сая төгрөгийн залруулах гүйлгээ хийсэн бөгөөд тэдгээрийг нотлох баримт байхгүй, анхан шатны баримтын бүрдэл 412.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн. Мөн мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчиж бэлэн мөнгөөр 23.7 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

“Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг монгол банк, арилжааны банканд нээх хаах журам”-ыг зөрчиж СЯ-ны зөвшөөрөлгүйгээр ГХБХБГ нь газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлэхээр Төрийн банканд тэг үлдэгдэлтэй данс нээсэн, Улаанбадрах сумын багийн ажлын алба Төрийн банканд хандивын данс нээсэн байсан.

Аудитаар нийт 1.3 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж, холбогдох 8 газарт 12 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн бөгөөд албан шаардлага 100 хувь хэрэгжээд байна. Өгөгдсөн зөвлөмжүүд хэрэгжих шатандаа явж байна.

2.2 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Төрийн аудитын газрын 2018 үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 6 гүйцэтгэлийн аудит хийхээр тусгасан бөгөөд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар 1 аудит, өөрсдийн санаачилгаар 3 аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 9,294.4 сая төгрөгийн зөрчил илрүүлсний 79.4 хувийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 8.9 хувийг хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 5.1 хувийг НББ, тайлагналтай холбоотой, 6.6 хувийг дотоод хяналттай холбоотой зөрчил эзэлж байна. Гүйцэтгэлийн аудитаар 430.7 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт, 2,250.4 сая төгрөгийн зөрчилд 39 албан шаардлага, 6,613.3 сая төгрөгийн зөрчилд 51 зөвлөмжийг өглөө.



2.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгуудын хэрэгжилт, үр дүн /YAГ-ын нэгдсэн удирдамжаар/

Тус аймгийн Замын-Үүд суманд 2013 оноос хэрэгжиж эхэлсэн Соёл спортын цогцолбор, 100 ортой эмнэлэг, Хатанбулаг суманд Соёл спорт цогцолборын барилга угсралтын ажил, Сайншанд суманд 2011 оноос хэрэгжиж эхэлсэн 50 ортой төрөх эмнэлгийн барилгууд 5-7 жил үргэлжлэн дуусаагүй байна. Хатанбулаг сумын Соёл спорт цогцолборын барилга угсралтын ажил, Сайншанд сумын 50 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлыг YAГ-аас томилогдсон гэрээт шинжээчид дүгнэлт гаргахаар ажиллалаа. Тухайлбал: Хатанбулаг сумын Соёл спорт цогцолборын барилга угсралтын ажлыг МУ-ын ШУТИС-ийн Барилга Архитектурын сургуулийн салбарын эрхлэгч н.Биндэръяа шалгаж, 2018 оны 05 дугаар сард тус суманд ажиллаж барилгын материал, хийцэд шинжилгээ авч явсан.

Сайншанд сумын 50 ортой Төрөх эмнэлгийн барилгын ажлыг 2018 оны 04 дүгээр сарын 26 ны өдөр Халтар-Асга ХХК-ийн хяналтын инженер н.Батбаяр шалгаж, барилгын зураг төсвийн дагуу хэмжилт хийсэн.

Аудитын дүн, дүгнэлт YAГ-ын нэгдсэн тайланд тусгаагдах болно.

2.2.2 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөө/ YAГ-ын нэгдсэн удирдамжаар/



Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Сайдын багцаас тус аймагт 2.4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр захиалагчийн эрх шилжүүлэн, 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Орон нутагт хэрэгжүүлсэн улсын төсвийн хөрөнгийн санхүүжилтийн 27 хувийг боловсролын салбарт, 67 хувийг эрүүл мэндийн салбарт, 4 хувийг бусад салбарт зарцуулахаар тус тус хуваарилжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүй, зарим засварын ажил эхлээгүй байхад комиссын актаар хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон, Барилга байгууламжийн зохиогчийн хяналтыг дүрмийн дагуу хэрэгжүүлээгүй, захиалагч гэрээний заалтуудыг мөрдөж, дүгнэж ажилладаггүйгээс гүйцэтгэгчийн гаргасан алдаа зөрчилд хариуцлага тооцох ажил орхигдсон зэрэг зөрчил илэрсэн.

Аудитаар нийт 628.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 53.9 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч, хөрөнгө оруулалтын үр нөлөө, захиалагчийн хяналтыг сайжруулахад чиглэсэн 4 зөвлөмжийг хүргүүлжээ.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Орон нутгийн төсвөөс 28 төсөл арга хэмжээнд 5331.0 сая төгрөг, замын сангийн санхүүжилтээр 13 төсөл арга хэмжээнд 639.5 сая төгрөг, нийт 44 төсөл арга хэмжээнд 5970.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Мөн Замын-Үүд сум 747.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тухайн онд хэрэгжих ТАХ-г аймгийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагуудад 747.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлсэн нь хуулиар тогтоосон орон нутгийн төсвийн чиг үүрэгтэй нийцээгүй, хөрөнгө оруулалтын ирээдүйд бий болох үр өгөөж, хэрэгцээ шаардлагыг урьдчилан тооцоогүйгээс хөрөнгийн ашиглагч тодорхойгүй, зарим ажил чанарын болон ашиглалтын шаардлага хангаагүй, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж хариуцлага тооцоогүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Аудитаар нийт 3902.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 23.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 480.5 сая төгрөгийн 6 албан шаардлага бичиж 3926.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

2.2.3 “Өмнөх онуудад орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүн” гүйцэтгэлийн аудит



Аудитыг аймгийн Төрийн аудитын газрын санаачилгаар 2018.06.11-2018.09.14 өдрийн хугацаанд гүйцэтгэж “Хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна” гэсэн дүгнэлт өглөө.

Захиалагч, гүйцэтгэгчийн ажлын хариуцлагагүй байдлаас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013-2017 онд хэрэгжүүлсэн 244.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ өнөөг хүртэл дуусаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл чанаргүй, дутуу гүйцэтгэсэн байхад хүлээн авч “Хөрөнгийг ашиглалтад оруулах комиссын акт” үйлдсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцоогүй байна.



Шат шатны ИТХ болон Засаг дарга нар хуульд заасан орон нутгийн өмчийн талаарх бүрэн эрхээ хангалтгүй хэрэгжүүлж ажилласан байна.

Ашиглагч байгууллага хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл тайлагнал, хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулах талаар ажил зохион байгуулаагүйгээс хөрөнгө ашиглалтгүй байсаар байна.

Хөрөнгө оруулалтын үр дүнг хангахад чиглүүлсэн, алдаа дутагдал давтан гарахаас сэргийлэх, арилгах чиглэлээр өгөгдсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны байгууллагууд идэвх санаачилгагүй ажилласан ба хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнд тавих хяналт орхигдсон байна.

Аудитаар нийт 2442.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 3 зөвлөмж өгч, 1525.0 сая төгрөгийн 20 албан шаардлага хүргүүллээ.

2.2.4 “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит



Аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар 2018.09.27-2018.10.26-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж “Үдийн цайнд лабораторын шинжилгээний дүгнэлтгүй бүтээгдэхүүн нийлүүлж байна ” гэсэн дүгнэлт өглөө.

Аудитаар Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг зарим сургуулиуд зориулалтын дагуу зарцуулаагүй, үдийн цайнд нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамрагдсан эсэхийг харгалзаж тендерт шалгаруулаагүйгээс шинжилгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байна.

Ихэнх сумд үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэх хуулийн этгээдийг чөлөөт өрсөлдөөнгүйгээр хамтран ажиллах гэрээ байгуулж ирсэн, сургуулиуд үдийн цайны цэсийг журмын дагуу боловсруулж, хянаагүйгээс хориглосон бүтээгдэхүүн нийлүүлэгдсэн байна.

Бэлтгэн нийлүүлэгч бүтээгдэхүүний илчлэг нормын шалгуурыг хангасан, хүүхдийн нас биед тохирсон амин дэм, эрдэс бодисоор баяжуулсан бүтээгдэхүүнийг сургуулиудад нийлүүлж чадахгүй байна.

Үдийн цайны цэс боловсруулах аргачлал байхгүйгээс сургуулиудын зохиосон цэсэд бүтээгдэхүүний илчлэг, грамм, үнэ тусгагдаагүй, олгох сар, өдөр гариг нь тодорхойгүй байна.

Үдийн цай хөтөлбөрт бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэх ажил хангалтгүй байна.

Хяналтын комиссын бүрэлдэхүүн Үдийн цай хөтөлбөрийн холбогдох журмыг судалж үйл ажиллагаагаа жигдрүүлэх, хяналтыг үр нөлөөтэй болгох шаардлагатай байна.



Аудитаар нийт 520.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, холбогдох албан тушаалтанд 7 зөвлөмж хүргүүлж, үдийн цайнд нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүнийг нян болон хими хор судлалын шинжилгээнд хамруулж, зохих үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлэх, цэсэд орсон бүтээгдэхүүний нийц, зохицлыг зөв сонгосон байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулахыг сумын Засаг даргад хариуцуулж 10 албан шаардлага, Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуулийн эмчид хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, нийт 11 албан шаардлага хүргүүлэв.

2.2.5 “Орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн санд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудит



Аудитыг аймгийн Төрийн аудитын газрын санаачилгаар 2018.06.25-2018.09.24 өдрийн хугацаанд гүйцэтгэж “Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй байна” гэсэн дүгнэлт өглөө.

Нийгмийн халамжийн мэргэжилтнийг мэргэшүүлэн чадваржуулах, амьжиргаа дэмжих зөвлөлийг арга зүйгээр хангаж ажиллах хэрэгтэй байна.

Аудитаар өрхийн мэдээллийн сангийн мэдээллийн үнэн зөв байдалд анхаарч ажиллаагүй, халамжийн сангаас олгох зарим зардлуудыг судалгаа болон бодит гүйцэтгэлд үндэслэн тооцоогүй, нөхцөл байдлыг зөв үнэлж төлөвлөөгүй байна. Мөн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтад тавих хяналт дутагдсанаас алдарт эхийн одонгийн мөнгө, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд амралт, сувилуулсны хөнгөлөлтийг илүү тооцож олгосон. Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаанд зохих шатны хяналт шалгалт хийгддэг ч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй. Хүнсний эрхийн бичгийн олголт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитаар нийт 7,070.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 515.1 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож 7,070.4 сая төгрөгийн зөрчилд холбогдох 5 зөвлөмжийг хүргүүллээ. Тайлант онд тогтоосон 515.1 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт бүрэн барагдаад байна.

2.2.6 “Аймгийн орон нутгийн төсвийн татварын бус орлого бүрдүүлэх үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит

Аймгийн Төрийн аудитын газрын санаачилгаар тус аудитыг 2018.11.19-2018.12.25 хүртэлх хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулаад байна.




Одоогоор аудит гүйцэтгэлийн шатанд явж байгаа бөгөөд аймгийн татварын бус орлогыг бүрдүүлэгч аймгийн ШШГГ, Цагдаагийн газар, Замын-Үүд сумын ШШГХэсэг, Цагдаагийн хэлтэс, Хилийн мэргэжлийн хяналтын алба, аймгийн МХГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар зэргийг хамруулан хүү торгууль, түрээсийн орлогын бүрдүүлэлтийг шалгаж байна.

2.3 НИЙЦЛИЙН АУДИТ

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 6 нийцлийн 3 аудит хийхээр тусгасан бөгөөд УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар 1 аудитыг тус тус гүйцэтгэлээ.

Аудитад 1 аудитор 69 хүн/цаг, 32 илүү цаг зарцуулж, 16.2 сая төгрөгийн өртөг зарцуулсан байна.

2.3.1 “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт” нийцлийн аудит



Аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар 2018.03.01-2018.06.27 өдрийн хугацаанд гүйцэтгэж “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт сайжирсан байна” гэсэн дүгнэлт өглөө.

Аудитаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хууль, журмын дагуу боловсруулж, мөрдөж ажилласан эсэх, газрыг хуульд заасны дагуу өмчлүүлж буй эсэх, газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хууль журмын дагуу хяналтыг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод мэдээлсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өглөө.

2017 оны жилийн эцсийн байдлаар тус аймагт гэр бүлийн хэрэгцээний газрыг үнэгүй өмчлөх үйл ажиллагаа 25 хувьтай байна гэж дүгнэсэн бөгөөд газрын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт сайжирсан байна гэж дүгнэлээ.

Аудитаар худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний газарт байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрын зарим хэсгийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, гэрээнд заасан газрын хэмжээг хэтрүүлэн эзэмших, хуульд заасан хүндэтгэх шалтгаангүйгээр 2 жил болон түүнээс дээш хугацаагаар ашиглаагүй, гэр бүлийн хэрэгцээний газрыг нэг удаа үнэгүй өмчлөх тухай хуулийн заалтыг зөрчин 25 иргэнд 6.7 га газрыг давхардуулан олгосон зэрэг зөрчил илэрсэн.

Дээрх аудитаар хууль зөрчиж өмчлүүлсэн 25 иргэний газар эзэмших эрхийг хүчингүй болгох 1 албан шаардлага, хяналт хариуцлагыг дээшлүүлэх 19 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ. Албан шаардлага 100 хувь хэрэгжээд байна.



2.3.2 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудит



Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2018.10.15-2018.11.28 өдрийн хугацаанд гүйцэтгэж “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна” гэсэн дүгнэлт өглөө.

Аймгийн хэмжээнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа явуулж байгаа 178 байгууллагаас 168 байгууллагыг хамруулан шалгалаа.

Аудитаар тухайн жилийн төсвийг 13 байгууллага буюу 29.8 хувь нь, хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг 10 байгууллага буюу 6.7 хувь нь, дараа жилийн төсвийн төслийг 35 байгууллага буюу 21.3 хувь нь, хагас жилийн санхүүгийн тайланг 21 байгууллага буюу 13.5 хувь нь, аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 25 байгууллага буюу 18.5 хувь нь, төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 96 байгууллага буюу 55.1 хувь нь мэдээлээгүй байна.

Мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай гарсан тушаал шийдвэрийг бүрэн мэдээлдэггүй зөрчил байсаар байна. Тухайлбал: 2017 оны 4-р улирлаас 2018 оны 1-3 улирал хүртэлх хугацаанд зарлагын нийт 1534.6 сая төгрөгийн 148 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 5758.6 сая төгрөгийн 214 гүйлгээг тус тус мэдээлээгүй. Мөн хугацаанд 178 байгууллагад нийт 33315.7 сая төгрөгийн 3600 хөрөнгө зарцуулах тухай шийдвэр гарсан байхад 3831.6 сая төгрөгийн 820 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ талаарх мэдээллийн төсвийн байгууллагууд мэдээлж байгаа боловч гүйцэтгэж байгаа ААНБ-ууд шилэн дансанд цахим хуудас нээлгээгүй, холбогдох мэдээллийг мэдээлээгүй байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч Замын-Үүд сумын хувийн өмчит 1 сургууль, 4 цэцэрлэг, Сайншанд сумын Төмөр замын МСҮТ зэрэг байгууллагууд хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байлаа.

Аудитаар 11432.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 23 албан шаардлага тогтоож, холбогдох албан тушаалтанд 3 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.



2.3.3 “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн” нийцлийн аудит



Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2018.09.14-2018.11.28 өдрийн хугацаанд гүйцэтгэж “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангуудын үйл ажиллагааны үр дүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна” гэсэн дүгнэлт өглөө.

Орон нутгийн хөгжлийн сан:

Аудитад 14 сум, аймгийн ОНХС-г хамруулан, 2017 оны төлөвлөлт, зарцуулалтад аудит хийлээ. 2017 онд ОНХС-аас тус аймагт 2307.0 сая төгрөгийг хуваарилсан байна. Үүнээс 687.0 сая төгрөгийг “Тогтвортой амьжиргаа 3” төслийн хүрээнд Сангийн яамнаас сумдын ОНХС-д шууд шилжүүлсэн байна. Тайлант онд сангийн нийт эх ОНХС болон бусад эх үүсвэрээс нийт 2717.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2017 онд нийт 55 ТАХ-г шинээр хэрэгжүүлсэн байна. Эдгээр ТАХ-хэрэгжүүлэхдээ ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналаар дэмжигдээгүй, чиг үүрэгт тусгагдаагүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй, ХБББ-тэй уялдаагүй ТАХ-г хэрэгжүүлсэн зөрчил нийтлэг илэрч байна. Мөн ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий сумдын ИТХ үүргээ биелүүлж ажиллаагүй байна.

Мөн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үйл явцад дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг Аймгийн Засаг дарга томилоогүйгээс ОНХС-ийн зааварт тусгагдсан зарим ажлууд хийгдээгүй байна.

Сум хөгжүүлэх сан:

Аймгийн хэмжээнд 2017 онд 9 сум 80 төсөлд 843.4 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

СХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй, зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт болон сангийн үйл ажиллагаанд хяналт тавих үйл ажиллагаанд зардал төлөвлөөгүй байна. Мөн СХС-аас олгох зээлийг аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, болон ЖДҮ-ийг хөгжүүлэх бусад бодлого шийдвэрт нийцүүлж төсөл арга сонгон шалгаруулаагүй байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналд тавих хяналт хангалтгүйгээс зээлийн эргэн төлөлт удаашралтай, зээлийг зориулалт бусаар зарцуулсан, гэрээний үүргийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг үр дагавар бий болгож байна.



СХС-ийн зээл, зээлийн хүүгийн авлагыг анхан шатны баримт материалыг үндэслэн үнэн зөв тооцож бүртгээгүй, зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлээгүй, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулаагүй байлаа.

Аудитаар нийт 1,864.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 13.0 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 608.0 сая төгрөгийн 13 албан шаардлага хүргүүлж, холбогдох албан тушаалтанд 11 зөвлөмжийг өгч ажиллалаа.



СУРГАЛТ



Монгол улсын Ерөнхий аудитор 2018 оныг “Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан сургалтын төлөвлөгөө боловсруулж нийт 13 сургалт зохион байгуулаад байна.

3.1 Дотоод сургалт

- Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа “Эрүүл мэнд, боловсролын салбарын төсөв, санхүүтэй холбоотой шинээр гарсан хууль, журам”-ын талаар дотоод сургалтыг зохион байгууллаа.
- Мөн 2018.09.03-ны өдөр байгууллагын ажилчдад менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа “Аудитын үйл ажиллагааг зохицуулсан журам”, “аудитын чанар үр нөлөөг дээшлүүлэх” сэдвээр сургалт зохион байгууллаа.
- Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмын талаарх сургалтыг Дотоод ажил хариуцсан ажилтан Х.Саруулбуян
- Аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, Гүйцэтгэлийн аудитын үр ашиг, үр нөлөөт байдал, Нийцлийн аудитын арга хандлага сэдэвт дотоод сургалтуудыг зохион байгууллаа.

3.2 Бусад байгууллагаас авах сургалт

- 2018.04.27-ний өдөр Улаанбаатар хотын Хан голомт сургалтын төвтэй хамтран “Хувь хүний хөгжил-Багийн хөгжил-Байгууллагын хөгжил” гэсэн сэдвүүдээр нэг өдрийн сургалт зохион явуулав.
- 2018.05.09-ний өдөр Соёлын тухай болон Соёлын өвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар угийн бичиг хөтлөх ажлыг бүх нийтийн хүртээл болгох, эрчимжүүлэх ажлын хүрээнд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газраас угийн бичиг хөтлөх ажлыг албан хаагчдад танилцуулах, угийн бичиг хөтөлж сурах дадлага олгох зорилгоор аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс мэргэжилтэн Ц.Өлзийжаргалыг урьж дотоод сургалт зохион байгуулав.



- 2018.05.25-ны өдөр Дорноговь аймгийн Тагнуулын хэлтсийн ажилтнуудыг урьж тус газрын албан хаагчдад Төрийн болон албаны нууцын тухай хууль эрхзүйн орчин болон төрийн нууцыг хэрхэн хадгалж, хамгаалах талаар сургалт зохион байгууллаа.
- 2018.06.14-ний өдөр тус аймгийн Шүүхийн тамгын газраас шүүхийн нээлттэй ил тод байдал, шүүхийн шинэчлэл, иргэний хэргийн шүүх, захиргааны хэргийн шүүхийн талаарх сургалтыг зохион байгууллаа.
- Аймгийн Засаг даргаас хэрэгжүүлж буй “Нийгмийн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд ЭМГ-ын хоол судлал, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтнийг урьж авчран “Эрүүл зөв зохистой хооллолт” сэдвээр албан хаагчдад сургалт явууллаа. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан төсвийн байгууллагуудын гар бөмбөгийн тэмцээнд байгууллага, хамт олноороо амжилттай оролцсон.



Сангийн яамнаас зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны аудит” сэдэвт сургалтанд 2 аудиторыг хамруулж, “Шинэ ажилтны сургалт”-д шинээр ажилд орсон 3 аудиторыг оролцуулж ажиллалаа. Мөн аудитын менежерүүдийн сургалтад Ч.Хэрлэнчимэг оролцлоо.





2018.10.12-ны өдөр ҮАГ-аас “Төрийн аудитын байгууллагын бүсчилсэн сургалт”-ыг зохион байгуулсан. Сургалтад Дорноговь, Говьсүмбэр аймгийн нийт 16 аудитор оролцож, Үндэсний аудитын газрын Стратеги удирдлагын газрын дарга Д.Энхболд, ахлах шинжээч Б.Өлзий болон Тамгын газрын хүний нөөцийн мэргэжилтэн Г.Өлзийдэлгэр, сургалт хариуцсан ажилтан М.Өлзиймягмар, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын менежер У.Оюунхүү нар төрийн аудитын байгууллагын албан хаагчдад сургалтын хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай мэдээллийг өгч, сургалтыг удирдан явуулав.

Сургалтаар санхүүгийн тайлангийн аудитын шинэ журам, гүйцэтгэлийн аудитын арга зүй, дүрэм журмын өөрчлөлт, шинэчлэлийн талаар сургалт хийж, төрийн аудитын байгууллагын харилцагч талуудын оролцооны стратегийн бодлогын баримт бичиг боловсруулах асуудлаар хэлэлцүүлэг явууллаа.



Мөн МУ-ын Ерөнхий аудиторов 2015 оны 18 дугаар тушаалаар батлагдсан төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах мэргэжлийн шалгалтад аудитор Б.Тунгалагтуяа 90 үнэлгээ, аудитор Б.Уранбилэг 85 үнэлгээг тус тус авсан.



ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ



Аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ерөнхий аудиторов орон нутаг хариуцсан орлогчтой 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулж, ажилчидтай үр дүнгийн гэрээг 2018 оны 03 дугаар сарын 28-ний өдөр байгууллаа.

4.1 Архив, бичиг хэрэг

Аймгийн Засаг даргын дэргэдэх Архивын тасгаас ирүүлсэн албан бичгийн дагуу байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан 2003-2013 оны байнга хадгалах баримтыг төрийн архивт шилжүүлэх, тэдгээрийг батлагдсан данс бүртгэлээр хүлээлгэн өгөх, байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



4.2 Санхүү, нягтлан бодох бүртгэл

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хөтлөж, жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 албан даалгаврын хүрээнд ажлын хариуцлага, сахилга бат, дэг журмыг чангатгах үүднээс дараах ажлыг зохион байгууллаа.

- Байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт явуулахаар аудитор Б.Тунгалагтуяа, аудитор О.Нарангарав нарыг томилон ажиллуулсан.
- Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хяналт тавих зорилгоор хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмж худалдан авсан.
- Байгууллагын даргын, архивын, нууцын өрөөнүүдэд лац хийлгэсэн.
- Хяналтын веб камер худалдан авч суурилуулсан.

Эд хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж, тооллогоор 144 нэр төрлийн 13.4 сая төгрөгийн бараа материалыг тоолж, тооллогын комиссын шийдвэрээр ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан 23 нэр төрлийн 2.2 сая төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хасаад байна. Мөн Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс гарсан шийдвэрээр ашиглах боломжгүй, ашиглах хугацаа дууссан 8 нэр төрлийн 7098.8 мянган төгрөгийн 20 ширхэг үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасуулах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлээд байна.

Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Үндэсний аудитын газрын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ирсэн 5 нэр төрлийн 3.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээд байна.

ТАБ-ын хэмжээнд үг, үсгийн алдаа шалгагч програм нэвтрүүлж байгаатай холбогдуулан Болор дуран програмыг үндсэн хөрөнгийн программ хангамжийн данс бүртгэлд бүртгэн бүрэн ашиглаж байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/152 дугаар тушаалыг үндэслэн зарцуулж, 9.4 сая төгрөгөөр 5 ширхэг иж бүрэн компьютер, нууцын өрөөний тоног төхөөрөмж, цаас устгагч зэрэг хөрөнгийг худалдан авлаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татвар, НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд, 2019 оны төсвийн төслийг УАГ-т хүргүүлээд байна.



Мэдээллийн ил тод байдлыг хангаж шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд байршуулсан мөн хуулийн хугацаанд илгээж байна.

Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны самбарт санхүүгийн тайлан, Аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн мэдээг тогтмол сар бүр, тухай бүр мэдээлж байна.

4.3 Ажилчдын ажиллах нөхцөл, шагнал урамшуулал

Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Л.Аваадорж Төрийн аудитын байгууллагад 11 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд ТАБ-ын үйл ажиллагаанд гаргасан амжилт бүтээлийг үнэлэн “Төрийн хяналтын тэргүүн” цол тэмдгээр шагнууллаа.



Ажилчдын эрүүл мэнд, ажлын байран дахь дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор 7 хоног бүрийн нэг өдөр спорт зааланд сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэх, ажлын байран дээр ширээний теннисний ширээ байрлуулж, ажилчдын спортоор хичээллэх нөхцөл боломжийг хангаж ажиллалаа.

Мөн сар бүрийн 20-нд нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ажил зохион байгуулах ЭМГ-ын санаачилга, уриалгын хүрээнд ажилчдын дунд буухиа тэмцээн, сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнийг дотооддоо зохион байгууллаа.



Монгол Улсын гавьяат багш У.Доёдын нэрэмжит математикийн улсын 54 дүгээр олимпиад Дорноговь аймагт 2018 оны 05 дугаар сард зохион байгуулагдсан. Монголын математикийн олимпиадын тугийг албан байгууллага аж ахуй нэгжээр аялуулж байгаа үйл ажиллагааг манай байгууллагын хамт олон дэмжиж, мөнгөн хандив өглөө.





Улс тунхагласны 94 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ажилд орж, МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар жинхлэн томилогдсон аудитор У.Оюунтүлхүүр, О.Нарангарав, Т.Мөнхтогтох нар “Төрийн аудитын байгууллагын ажилтны тангараг” өргөж төрийн жинхэнэ албан хаагч боллоо.



Ажилчдын нийгмийн асуудлыг шийдэх ажлын хүрээнд гэр байранд амьдардаг ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт 600.0 мянган төгрөгийг олгосон.

Ажилчдад орон тоо дутуугаас ажлын ачаалалтай ажилласан, ажлын үр дүн зэргийг харгалзан үзэж 2018 оны эхний хагас жилд 6158.6 мянган төгрөгийн урамшуулал олгоод байна.

4.4 Олон нийттэй харилцах чиглэлээр хийсэн ажил

ҮАГ-ын audit.mn цахим хуудаст аудитын тайлан, байгууллагын мэдээллийн самбарт санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын албаны тайлант онд хийсэн аудитын талаарх товч мэдээллийг байршуулж, мэдээллийн санг тогмол шинэчлэн ажиллалаа.

Аймгийн удирдах ажилтаны зөвлөгөөнийг 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус зөвлөгөөнд дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа “Санхүүгийн удирдлага, хяналт” сэдвээр мэдээлэл хийлээ.



Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны сургалтад 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал, шалтаан, үр дагаврын талаар мэдээлэл хийв. Мөн Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан аймгийн төвийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнд аудитаар илэрсэн зөрчил, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч ажиллалаа.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА